




2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН



АГУУЛГА

01. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

Компанийн тухай
Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйл
Үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээ

02. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2023 оны хагас жилийн үйл ажиллагааны товч тайлан
Зах зээлд шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээ
Оролцсон арга хэмжээнүүд
Онцлох хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд

03. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Борлуулалтын орлого болон нийт ашгийн маржин
Цэвэр ашиг, цэвэр ашгийн маржин
Нийт хөрөнгийн өгөөж
Эздийн өмчийн өгөөж
Нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг, P/E болон P/B харьцаа

Компанийн тухай

Манай компани нь Монгол Улсад мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд 2012 оноос эхлэн домэйн нэрийн бүртгэл, веб хост, сервер байршуулалт, виртуал серверийн түрээс, и-мэйл сервисийн ашиглалт зэрэг интернет технологид суурилсан бүтээгдэхүүн, үйчилгээг аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүст үзүүлж тэдгээрийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг ханган ажилласаар ирсэн. Компани нь өнгөрсөн 11 жилийн хугацаанд мэдлэг чадвартай ажилтан, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нийлүүлэн салбарынхаа тэргүүлэх компани болохыг зорьж ажилласан ба 2017 оны 09 сараас эхлэн өмчийн хэлбэрээ өөрчлөн, хувьцаат компани болсон.


КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА



ЭРХЭМ ЗОРИЛГО

Дижитал орчны үнэ цэнийг хүчирхэгжүүлэх найдвартай суурь нь байна


To be the trusted foundation to strengthen the value of the digital environment



АЛСЫН ХАРАА

Дэлхийн жишигт нийцсэн дата төвд хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, эргэлзээгүй сонголтыг бий болгоно.

Provide customer information security in a world-class data center and create an undeniable choice.



ҮНЭТ ЗҮЙЛС

Бид - Үнэнч хариуцлагатай, Эелдэг, Стандарт хэрэгжүүлэгч, Чадварлаг, Хурдан шуурхай, Шинийг санаачлагч

Loyal, Responsible, Kind, Standard implementer, Competent and Fast, Innovative

ДАТА ТӨВИЙН ТУХАЙ



01

ЦАХИЛГААНЫ НАЙДВАРТАЙ ЭХ ҮҮСВЭР

- Нөөц эх үүсвэр
- Тоног төхөөрөмж бүр тог баригч төхөөрөмжид холбогдсон

02

ХОСОЛМОЛ ИНТЕРНЭТИЙН УРСГАЛ

- Сүлжээний найдвартай холболт
- CLOUD ddos хамгаалалт

03

ДАТА ТӨВИЙН ОРЧИН

- Зориулалтын зогсуур
- Автомат хөргөлтийн систем
- Орчны хяналтын систем
- Галын хамгаалалтын систем

04

МЭРГЭЖЛИЙН БАГ

- 24x7 Хяналт, Тусламжийн үйлчилгээ
- 10 жилийн туршлагатай инженер техникийн баг
- Дэвшилтэт шинэ технологи

05

ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

- Олон улсын TIER 2 Стандартын шаардлага хангасан
- ISO 9001:2015, ISO/IEC 27001:2013 олон улсын стандартын шаардлага хангасан

ҮНДСЭН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ



ДОМЭЙН НЭР



ВЭБ БАЙРШУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ



WEBDY ҮЙЛЧИЛГЭЭ



БИЗНЕС И-МЭЙЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



MAILDY ҮЙЛЧИЛГЭЭ



СЕРВЕР БАЙРШУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ



СЕРВЕР ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ



CLOUD МН | Үндэсний
Клауд
КЛАУД ҮЙЛЧИЛГЭЭ



SSL СЕРТИФИКАТЫН ҮЙЛЧИЛГЭЭ
WAF ХАМГААЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ



MICROSOFT 365 ҮЙЛЧИЛГЭЭ

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ISO 9001:2015 Олон улсын стандартын гэрчилгээгээ гардан авлаа



Бид 2022 оны 08 дугаар сараас эхлэн ISO хэрэгжүүлэх төслийн багийг байгуулан стандартыг үе шаттай нэвтрүүлэх төлөвлөгөө гаргаж ажилласан ба 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Олон улсын сургалт, баталгаажуулалтын Мон Майнинг Сертификейшин ХХК-аас “Айтүүлс” ХК-ийн үйл ажиллагаанд аудит хийж, тохирлын үнэлгээ, хяналт шинжилгээгээр ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо олон улсын стандартын шаардлагыг бүрэн хангасан тул ийнхүү баталгаажуулалтын гэрчилгээг гардууллаа.


ISO/IEC 27001:2013 олон улсын стандартын
Гэрчилгээгээ гардан авлаа



2023 оны 03 дугаар сарын 29, 30-ны өдөр Олон улсын BSCIC Certifications Pvt.Ltd-с “Айтүүлс” ХК-ийн үйл ажиллагаанд аудит хийж, тохирлын үнэлгээ, хяналт шинжилгээгээр ISO/IEC 27001:2013 стандартын шаардлагыг бүрэн хангасан тул ийнхүү 2023 оны 5 сарын 16-ны өдөр албан ёсоор сертификатаа гардан авлаа

БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Дата төвийн өргөтгөлийн ажил хийгдлээ



2023 оны эхний хагаст дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэн өргөтгөлийн ажлыг хийлээ. Уг өргөтгөлийн ажлын үр дүнд дата төвд байршуулах серверийн тоног төхөөрөмжийн тоо нэмэгдэж байгаа юм. 2023 оны эхний хагас жилд Айтүүлс ХК дата төв нь 99.98 хувийн тасалдалгүй ажиллагаатай байсан нь ОУ-н дата төвийн TIER стандартын TIER 3 түвшний үзүүлэлтийг хангахуйц сайн үзүүлэлт байлаа

IPV6 Амжилттай нэвтрүүлэв



Айтүүлс ХК нь дэлхий даяар өрнөж буй уг шилжилттэй хөл нийлүүлэн IPv6 нэвтрүүлэлтийг амжилттай хийлээ. Мөн бид 2023 онд нийт бүтээгдэхүүн үйлчилгээний 60%-д IPV6-г нэвтрүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

Техникийн дэмжлэгийн хэлтэстэй боллоо



Бид 2023 он 06 дугаар 01 өдрөөс эхлэн техникийн дэмжлэг үйлчилгээ үзүүлэх хэлтэстэй боллоо. Техникийн дэмжлэг үйлчилгээний хэлтэс нь хэрэглэгчдэд стандартад нийцсэн сервер, системийн ашиглалтын дараах дэмжлэг, техникийн тусламж үйлчилгээг цогцоор нь санал болгож байна.

ЗАХ ЗЭЭЛД ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ



MICROSOFT 365

2023 оны 02 дугаар сараас эхлэн MICROSOFT корпорацийн албан ёсны хамтрагч байгууллага боллоо. Ингэснээр байгууллагуудад зориулсан Microsoft 365 цогц үйлчилгээг албан ёсны эрхтэйгээр санал болгож байна.



WORDPRESS хостинг

Хэрэгцээ- Дэлхий дээр нийт сайтын 43 % нь Wordpress хост байна
Хялбар-Хэрэглэгчид хялбар удирдах боломж олгох
Хурд-Cache технологи болон SSD хард хэрэглэж буй учир илүү хурдтай ажиллах



SSD Storage + Cache

9X- Response time
15X- Throughput
Уламжлалт Apache-с 28 дахин хурдан
3X-Backup
10X- Cache+SSD storage
Бичил уншилтын хурд нэмэгдсэн

ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

“Нээлттэй Ирээдүй Дижитал Дархан 2023”
арга хэмжээнд хамтран зохион байгуулагчаар
оролцлоо



Голомт банкнаас санаачлан зохион байгуулсан “Дижитал Дархан 2023” арга хэмжээнд хамтрагч байгууллагаар оролцон өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээ болон үйл ажиллагааны талаар мэдээллийг Дархан хотын иргэд, аж ахуй нэгжүүдэд хуваалцлаа

MOM 2.0 Mongolia арга хэмжээний ивээн тэтгэгчээр оролцлоо



Айтүүлс ХК 2023 оны 4 сарын 1 өдөр Corporate Convention Center-т зохион байгуулагдсан "MOM 2.0: Маркетинг, технологи, бизнес сонирхогч 1000 ээжийн чуулга уулзалт" арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцлоо.

TECH IS UNLIMITED уриатайгаар
“ICT EXPO 2023”-д амжилттай оролцлоо.



“TECH IS UNLIMITED” уриан дор брошюр, цаасан хэвлэл ашиглахгүй бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулах боломж бүхий Webdy- Хялбар веб сайт угсрах үйлчилгээгээ онцоллоо.


ОНЦЛОХ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР

Сэтгэл ханамжийн судалгаа тогтмол авч




Хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг хэмжих, үр дүнд тулгуурлан бүтээгдэхүүн үйлчилгээгээ сайжуурах зорилгоор хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч эхэлсэн.

BUG BOUNTY хөтөлбөр хэрэгжүүлэв.



Дотоод үйл ажиллагааны алдаа дутагдлыг илрүүлэх сайжруулах, ажилчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор BUG BOUNTY хөтөлбөрийг улирал бүр тогтмол хэрэгжүүлж, илрүүлсэн BUG бүрийг тухай бүрт тогтмол засварлаж эхлэв.



Sales Master хөтөлбөр хэрэгжиж эхлэв.



Борлуулалтыг сайжруулах, ажилчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ажилтан тус бүрийн борлуулалтыг урамшуулж эхлэв. Ингэснээр ажилтан бүр өөрийн хувь нэмрийг оруулж, нэмэлт орлоготой болох боломжийг нэмэгдүүлэв.


САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Хөрөнгө оруулалт (мян.төг)



БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО БОЛОН НИЙТ АШГИЙН МАРЖИН


Үзүүлэлтүүд	2021 Q2	2022 Q2	2023 Q2
Борлуулалтын орлого	924,105	1,700,810	1,906,829
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	468,751	1,006,984	1,277,933
Нийт ашиг	455,353	693,826	628,895
Нийт ашгийн маржин	49%	41%	33%



2023 оны эхний хагас жилд борлуулалтын орлого 1.9 тэрбум байсан бөгөөд энэ өнгөрсөн оны мөн үеэс 12%-ийн өсөлтийг үзүүлсэн байна. Гэвч валютын ханшийн өсөлт, мөн лицензийн төлбөрийн өсөлтөөс шалтгаалан борлуулсан бүтээгдэхүүний өртөг 2023 оны эхний хагас жилийн байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 27% өсч энэ нь компанийн нийт ашиг 9%-иар буурахад хүргэсэн байна.

ЦЭВЭР АШИГ, ЦЭВЭР АШГИЙН МАРЖИН


Үзүүлэлтүүд	2021 Q2	2022 Q2	2023 Q2
Цэвэр ашиг	62,972	16,741	186,385
Борлуулалтын орлого	924,105	1,700,810	1,906,829
Цэвэр ашгийнг маржин	7%	1%	10%



Хэдийгээр нийт ашгийн маржин буурсан ч 2023 оны эхний хагасын байдлаар компани 186 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан ба энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 11 дахин өссөн буюу 1013%-иар өссөн байна. Цэвэр ашгийн маржин өнгөрсөн оны мөн үед 1% байсан бол энэ оны хагас жилийн байдлаар 10% болж 9 нэгж %-иар өсжээ.

НИЙТ ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ


	2021 Q2	2022 Q2	2023 Q2
Цэвэр ашиг	62,972	16,741	186,385
Нийт хөрөнгө (дундаж)	3,963,929	3,874,851	4,897,392
ROA	1.59%	0.43%	3.81%



Компанийн нийт дундаж хөрөнгө өнгөрсөн оны мөн үеэс 26%-иар өссөн бөгөөд цэвэр ашиг 1000%-иар өссөнөөс үүдэн нийт хөрөнгийн өгөөж 880 дахин нэмэгдэж 0.43%-иас 3.81% болж өссөн байна.

ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨГӨӨЖ

	2021 Q2	2022 Q2	2023 Q2
Цэвэр ашиг	62,972	16,741	186,385
Нийт эздийн өмч (дундаж)	3,380,236	3,171,439	3,740,726
ROE	1.86%	0.53%	4.98%



Эздийн өмчийн дундаж дүн өнгөрсөн оны хагас жилтэй харьцуулахад 18%-иар нэмэгдсэн ба эздийн өмчийн өгөөж өнгөрсөн оны хагас жилийн байдлаар 0.53% байсан бол 4.98% болж өссөн үзүүлэлттэй байна.

НЭГЖ ХУВЬЦААНД НООГДОХ ЦЭВЭР АШИГ, P/E БОЛОН P/V ХАРЬЦАА

а. Нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг

Үзүүлэлт	2021 Q2	2022 Q2	2023 Q2
Цэвэр ашиг	62,972	16,741	186,385
Хувьцааны тоо (мянган)	34,452	34,452	34,452
EPS	1.83	0.49	5.41

Энэ оны хагас жилийн байдлаар нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг нь 5.41 төгрөг байгаа нь 2022 болон 2021 оны мөн үеүдтэй харьцуулахад өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд ялангуяа өнгөрсөн онтой харьцуулахад 10 дахин өссөн байна.

б. P/E харьцаа

Үзүүлэлт	2021 Q2	2022 Q2	2023 Q2
EPS	1.83	0.49	5.41
Хаалтын ханш (6 сарын 30-р)	119	71	59
P/E харьцаа	65.11	146.12	10.91

P/E харьцаа нь өмнөх онуудын хагас жилийн үзүүлэлттэй харьцуулсан үзүүлэлтийг доорх хүснэгтэд үзүүллээ. 2023 оны хагас жилийн хувьд хувьцааны үнэ буурсан үзүүлэлттэй, мөн нэгж хувьцаанд ногдох цэвэр ашиг өссөнтэй холбоотойгоор P/E харьцаа нь сайжирсан үзүүлэлттэй байна.

в. P/V харьцаа



Үзүүлэлт	2021 Q2	2022 Q2	2023 Q2
Нийт хөрөнгө	4,491,918	4,592,456	5,202,327
Өр төлбөр	966,598	1,071,828	1,241,503
Дансны үнэ	102	102.2	115
Хаалтын ханш (6 сарын 30-р)	119	71	59
P/V харьцаа	1.16	0.69	0.51

P/V харьцаа буюу хувьцааны ханшийг дансны үнэтэй харьцуулсан хүснэгтийг сүүлийн 3 жилээр доор үзүүллээ. Уг хүснэгтээс харахад 2023 оны хагас жилийн байдлаар нэгж хувьцааны дансны үнэ өмнөх жилүүдээс 13%-иар өсч, хувьцааны үнэ буурсантай холбоотойгоор P/V харьцаа сайжирсан үзүүлэлттэй байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Компанийн нийт хөрөнгө 2023 оны эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 13%, өр төлбөр 16%, эздийн өмч 13% өссөн үзүүлэлттэй байна.

Нийт актив болон пассивын бүтцийг сүүлийн 3 жилийн хагас жилийн байдлаар дараах графикаас харах боломжтой.



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА



Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
1-р хороо, Реженси Резиденс 201
ТООТ



+976-75755585



www.itools.mn
